## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |              | Зөрүү       |
|-----------------------|---|-----------------------|--------------|-------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл    |             |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | 93,377,560.1          | 90,283,346.3 | 3,094,213.8 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | 93,377,560.1          | 90,283,346.3 | 3,094,213.8 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | 1,442,790.2           | 1,377,580.3  | 6,804.8     |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 1,139,761.2           | 1,095,817.3  |             |
| 210101                | Үндсэн цалин  | 631,363.2             | 653,362.7    |             |
| 210102                | Нэмэгдэл  | 333,828.5             | 288,414.8    |             |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                 | 47,689.4              | 41,182.0     |             |
| 210104                | Урамшуулал  | 126,880.1             | 112,857.8    |             |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 144,710.1             | 137,376.8    |             |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                    | 98,844.5              | 94,086.0     |             |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                    | 11,466.4              | 10,139.5     |             |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                     | 9,173.1               | 8,834.1      |             |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                  | 2,293.3               | 2,095.0      |             |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                 | 22,932.8              | 22,222.2     |             |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой</b>                     | 42,147.7              | 41,449.5     |             |

|               |  |                     |                     |                       |
|---------------|--|---------------------|---------------------|-----------------------|
|               | <b>ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>  |                     |                     |                       |
| 210301        | Гэрэл, цахилгаан   | 4,278.1             | 3,749.8             |                       |
| 210302        | Түлш, халаалт  | 36,387.3            | 36,387.3            |                       |
| 210303        | Цэвэр, бохир ус  | 1,482.3             | 1,312.4             |                       |
| <b>2104</b>   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>46,956.2</b>     | <b>44,911.9</b>     |                       |
| 210401        | Бичиг хэрэг  | 13,489.4            | 13,437.1            |                       |
| 210402        | Тээвэр, шатахуун   | 11,834.4            | 10,246.5            |                       |
| 210403        | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 2,908.4             | 2,564.8             |                       |
| 210405        | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 399.0               | 387.5               |                       |
| 210406        | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 18,325.0            | 18,276.0            |                       |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>27,179.5</b>     | <b>26,950.4</b>     |                       |
| 210601        | Багаж, техник, хэрэгсэл  | 1,405.5             | 1,405.4             |                       |
| 210604        | Урсгал засвар  | 25,774.1            | 25,545.0            |                       |
| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>17,361.3</b>     | <b>11,432.2</b>     |                       |
| 210702        | Дотоод албан томилолт  | 17,361.3            | 11,432.2            |                       |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>23,574.2</b>     | <b>18,952.6</b>     |                       |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,980.0            | 11,637.9            |                       |
| 210803        | Даатгалын үйлчилгээ  | 400.0               | 396.0               |                       |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар   | 100.0               | 47.1                |                       |
| 210807        | Газрын төлбөр  | 80.0                | 34.5                |                       |
| 210808        | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | 8,014.2             | 6,837.1             | 6,804.8               |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>1100.0</b>       | <b>689.6</b>        |                       |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 1100.0              | 689.6               |                       |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>91,934,769.9</b> | <b>88,905,766.0</b> | <b>3,029,003.9</b>    |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>91,934,769.9</b> | <b>88,905,766.0</b> | <b>3,029,003.9</b>    |
| 213202        | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                                 | 91,925,689.0        | 88,896,685.2        | 3,029,003.8           |
| 213204        | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 9,080.9             | 9,080.8             | 0.1                   |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>93,377,560.1</b> | <b>47,625,716.4</b> | <b>- 45,751,843.7</b> |
| <b>1310</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>15,787,669.8</b> | <b>15,787,669.8</b> |                       |
| 131001        | Улсын төсвөөс санхүүжих  | 15,787,669.8        | 15,787,669.8        |                       |
| <b>1340</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                  | <b>77,589,890.3</b> | <b>31,583,340.9</b> | <b>- 46,006,549.4</b> |
| 134001        | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих                                 | 77,589,890.3        | 31,583,340.9        | - 46,006,549.4        |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         |                     | <b>254,705.7</b>    | <b>254,705.7</b>      |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |                     | 254,705.7           | 254,705.7             |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |                     | <b>5,408,596.1</b>  |                       |

|        |   |      |             |  |
|--------|---|------|-------------|--|
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |      | 8,508,028.2 |  |
| 62     | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                            | 50.0 | 47.0        |  |
| 620001 | Удирдах ажилтан                                   | 1.0  | 1.0         |  |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                                 | 42.0 | 43.0        |  |
| 620003 | Үйлчлэх ажилтан                                   | 7.0  | 5.0         |  |
| 620004 | Гэрээт ажилтан                                    |      |             |  |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Д/д | ҮЗҮҮЛЭЛТ  | ГҮЙЦЭТГЭЛ |
|-----|---|-----------|
| 1   | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 10,487.9  |
| 2   | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН  | 10,487.9  |
| 3   | Бараа, ажил үйлчилгээний зардал   | 10,487.9  |
| 4   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 10,487.9  |
| 5   | Урсгал засвар   | 10,487.9  |
| 6   | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР  | 10,487.9  |
| 7   | Нэмэлт санхүүжилтийн орлого   | 10,487.9  |
| 8   | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000.0   |
| 9   | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 6,487.9   |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлжээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн зорилт:

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулна.
2. Нийгмийн даатгалын санг бүрдүүлнэ.
3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хууль тогтоомжийн дагуу тогтоон олгоно.
4. Иргэд даатгуулагчийн нийгмийн даатгалын баталгааг хангана.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Нийгмийн даатгалын тухай хууль,
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

3. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
4. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
6. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
7. Төсвийн тухай хууль,
8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үзсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд 2017-2022 оныг дуусталх хугацааны тэтгэврийн тогтоолт, олголтод хийсэн хяналт шалгалтаар 57 иргэнтэй холбоотой 488.7 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчлийг илрүүлэн төлбөрийн акт тогтоосны барагдуулалт 30 хувьтай байна.

Мөн аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд 2020-2022 оныг дуусталх хугацааны тэтгэмжийн тогтоолт, олголт, хэлтсийн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад хийсэн хяналт шалгалтаар 27 иргэнтэй холбоотой 9.6 сая төгрөгийн тэтгэмж илүү олгосон, төсвөөс 3.4 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан зэрэгтэй холбоотой төлбөрийн акт тогтоосны барагдуулалт 95 хувьтай байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн /тухайн үеийн нэршлээр/ хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 2017-2022 оныг дуусталх хугацааны тэтгэврийн тогтоолт, олголтод хийсэн хяналт шалгалтаар 30 иргэнтэй холбоотой 67.3 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчлийг илрүүлэн төлбөрийн акт тогтоосны барагдуулалт 28 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,256,408.9 мянган төгрөгөөр буюу 20 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт  
/ мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт                              | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт     |
|---------------------------------------|----------------|-----------------|--------------|
| Б                                     | 1              | 2               | 3=2-1        |
| Эргэлтийн хөрөнгө дүн                 | 8,654,946.4    | 10,989,149.4    | 2,334,203.0  |
| Мөнгөн хөрөнгө                        | 5,408,596.1    | 8,508,028.2     | 3,099,432.1  |
| Авлага                                | 3,231,292.3    | 2,452,398.1     | -778,894.2   |
| Бараа материал                        | 15,058.0       | 28,723.0        | 13,665.0     |
| Үндсэн хөрөнгө                        | 387,641.1      | 309,846.9       | -77,794.2    |
| Нийт хөрөнгийн дүн                    | 9,042,587.41   | 11,298,996.34   | 2,256,408.93 |
| Нийт өр төлбөр                        | 81,071.3       | 554,150.6       | 473,079.3    |
| Цэвэр хөрөнгийн өмчийн дүн            | 8,961,516.1    | 10,744,845.7    | 1,783,329.6  |
| Засгийн газрын хувь оролцоо           | 283,902.9      | 283,902.9       | 0.00         |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн | 9,042,587.4    | 11,298,996.3    | 2,256,408.9  |

НДЕГ-ын даргын А/51 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын сангуудын давсан орлогыг тухайн сар бүрийн эцэст төвлөрүүлнэ гэж заасны дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 3,099,432.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн 2023 оны 7 дугаар сарын 01-ээс Засгийн газрын 248, 249 дүгээр тогтоол гарч тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Нийт авлагын хэмжээ өмнөх оноос 778,894.2 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлага барагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 309,846.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 77,794.2 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэл өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 15,787,669.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас 77,589,890.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 93,377,560.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвөөс 15,787,669.8 мянган төгрөгийн, улсын нийгмийн даатгалын сангаас 45,557,460.9 мянган төгрөгийн санхүүжилтүүдийг авч, 38,145,446.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, 322,965.7 мянган төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлснээр санд нийтдээ 99,813,542.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 93,449,207.7 мянган төгрөгийг зарцуулан, 6,364,334.8 мянган төгрөгийг НДЕГ руу буцаан төвлөрүүлсэн байна.

Сангийн нийт зардлын цэвэр гүйцэтгэл 90,283,346.3 мянган төгрөг байгаа бөгөөд батлагдсан төлөвлөгөөг 3,094,213.8 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц сангаас 4,000.0 мянган төгрөгийн, Практикал даатгалаас 6,487.9 мянган төгрөгийн, нийт 10,487.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн 10,487.9 мянган төгрөгийг урсгал засварт зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн байна

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 10 дугаар сарын 01-ээр гаргасан санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 87,887,497.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 878,875.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагатай* гэж үзсэн тул 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 98,581,494.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 985,814.9 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Энэ дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |           | Биелэлт |            |      |
|-----------------|------------------------|-----------|---------|------------|------|
|                 | Тоо                    | Дүн       | Тоо     | Мөнгөн дүн | Хувь |
| Албан шаардлага | 1                      | 141,903.0 | 1       | 141,903.0  | 100  |
| Нийт дүн        | 1                      | 141,903.0 | 1       | 141,903.0  | 100  |

#### 9.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилтнуудын ажлын ачааллыг харилцан адилгүй хуваарилсан, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтны тогтвор суурьшил алдагдсан, үйл ажиллагааны нягтлан бодогчийн ерөнхий журналын хөтлөлт шаардлагын түвшинд хүрээгүй зэргийг анхаарах шаардлагатай байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 25,041.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг таслан зогсоож, дахин давтан гаргуулахгүйн тулд зөвлөмж хүргүүллээ.

### **5.1 Төлбөрийн акт өгөгдөөгүй.**

### **5.2 Албан шаардлага өгөгдөөгүй.**

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

1. Он дамжсан 4,484.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат, зам барих ажлын гүйцэтгэл 13 хувьтай байхад санхүүжилтийн 19,289.9 мянган төгрөгийг бүрэн олгож Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3 дахь заалтыг зөрчсөн. Уг санхүүжилтийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

1. Он дамжсан 4,484.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулах, барагдаагүй тохиолдолд шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн данснаас хасах
2. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг олгохдоо Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах, гэрээний хугацаанд гүйцэтгэгч компаниар ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлыг хийлгэн ашиглалтад хүлээж авах
3. Төсвийн хөрөнгийг зарцуулахдаа "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 6.3-д "Байгууллага бараа, ажил үйлчилгээг нийлүүлсэн боловч төлбөрийг хараахан аваагүй үед төлөгдөөгүй дүнгээр авлага хүлээн зөвшөөрнө" гэж заасныг баримталж ажиллах

#### **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

1. Удирдлага нь 2022 онд аймгийн Засаг даргын шийдвэрээр үр дүнгийн урамшуулал авсан боловч тайлант онд НДЕГ-ын даргын шийдвэрээр өмнөх

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

оны үр дүнгийн урамшуулал 1,088.7 мянган төгрөгийг давхардуулан авсан байна.

2. Шаардлага хангаагүй ажилтанд 178.3 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

1. Аймгийн Засаг даргаас болон НДЕГ-аас ирсэн шийдвэрийн дагуу нэг ажлын үр дүнгээр урамшуулал давхардуулан авч төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох
2. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.3-д “Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно” гэж заасныг мөрдөн ажиллах
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг мөрдөж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | /мянган төгрөгөөр/<br>Үүнээс |     |              |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------------------------|-----|--------------|-----|---------|-----|
|                   |            |     |                                   |     |                          |     | Залруулсан                   |     | Залруулаагүй |     |         |     |
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо                          | Дүн | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Дүн               |            |     |                                   |     |                          |     |                              |     |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | /мянган төгрөгөөр/<br>Үүнээс |                     |                                      |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|--|-------------|---------------------|---------------|-----|-----------------|-----|------------------------------|---------------------|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |                     |               |     |                 |     | Зөвлөмж                      |                     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     |   |     |
|  | Тоо         | Дүн                 | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо                          | Дүн                 | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Удирдлага нь 2022 онд аймгийн Засаг даргын шийдвэрээр үр дүнгийн урамшуулал авсан байтал тайлант онд НДЕГ-ын даргын шийдвэрээр үр дүнгийн урамшуулал илүү тооцож авсан | 1           | 1,088,657           |               |     |                 |     | 1                            | 1,088,657           |                                      |                     |   |     |
| Авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй   | 1           | 4,484,703.5         |               |     |                 |     | 1                            | 4,484,703.5         |                                      |                     |   |     |
| Гэрээт ажлын гүйцэтгэл 13 хувьтай байхад санхүүжилтийг бүрэн олгосон.  | 1           | 19,289,863          |               |     |                 |     | 1                            | 19,289,863          |                                      |                     |   |     |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>24,863,223.5</b> |               |     |                 |     | <b>3</b>                     | <b>24,863,223.5</b> |                                      |                     |   |     |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |     |                 |     |          |                |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|
|  |             |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн            |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил       |             |                |               |     |                 |     |          |                |
| Дүн  |             |                |               |     |                 |     |          |                |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                       |             |                |               |     |                 |     |          |                |
| Шаардлага хангаагүй ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон. | 1           | 178,333        |               |     |                 |     | 1        | 178,333        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>178,333</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>178,333</b> |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА


АУДИТЫН МЕНЕЖЕР:

Х.БОЛДБААТАР

**БОЛОВСРУУЛСАН:**

АХЛАХ АУДИТОР:

Г.ЗАЯА



Огноо: 2024-03-20